



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 5/18

Модот

Г.Болор-Эрдэнэд сахилгын шийтгэл ноогдуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны 403 дугаар дүгнэлтээр Сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд “Хязгаарлалттай дүгнэлт” гарсан тул Санхүү албаны дарга Г.Болор-Эрдэнэд “Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Г.Болор-Эрдэнийг 05, 06, 07 дугаар сарын цалинг 20%-иар бууруулж олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж хариуцлагатай ажиллахыг (Г.Болор -Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

5.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд гомдол гарах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ